



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл сэргээх тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгасан “Жимобайл нэт” ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх 14200015 тоот тусгай зөвшөөрлийг 2026 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс сэргээсэнд тооцсугай.

2. Тусгай зөвшөөрлийг сэргээсэн хуулийн этгээдийн мэдээллийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР